



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 59

Мөрөн

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн  
хамгааллыг сайжруулах хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Засгийн газрын 2013 оны 281 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах" хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах" хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлж буй зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, холбогдох санхүүжилтийг жил бүр орон нутгийн төсөв, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сан, холбогдох байгууллагуудын жилийн үйл ажиллагааны төсөвт тусган ажиллахыг /аймгийн Засаг дарга/ А.Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцож аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд жил бүрийн 04 дүгээр улиралд багтаан танилцуулж байхыг аймгийн ЗДТГ-ын /Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга/ Ж.Ганболдод даалгасугай.

ДАРГА

Т.БОЛДБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2015 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн  
5.9 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, тэднийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход тулгарч буй аливаа саад бэрхшээлийг арилгах, ажил хөдөлмөр эрхэлж амьдралын чанараа өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх бодлогыг сүүлийн жилүүдэд Засгийн газраас онцгой анхаарч байна. Тиймээс Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеэ даасан хэлтсийг байгуулж тус хэлтэст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулснаар тэдний талаар томоохон бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчин өмнөх жилүүдээс илүү сайжирч байна.

Монгол Улс НҮБ-ын Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн хорооноос зарлаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмшүүлэх, саадыг арилгах, оролцоог тэгш зорилготой “Инчеоны стратегийг”-ийг 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Мөн Монгол Улсын засгийн газар 2013 оны 281 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан гаргасан.

Манай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2012 онд 4674 /Нийт иргэдийн- 3,74%/, 2013 онд 5250 / Нийт иргэдийн- 4,17%/, 2014 онд 5457/ Нийт иргэдийн- 4,32%/ байгаагаас үзвэл сүүлийн 3 жилд өссөн байгаа нь харагдаж байна.

Тэдний 913 нь сэтгэцийн эмгэгтэй, 1184 нь хөдөлгөөний, 651 нь харааны, 813 нь сонсголын, 612 нь хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байгаа бөгөөд 39,2% нь буюу 2144 нь төрөлхийн, 3314 нь буюу 60,8 хувь нь олдмол шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэд байна.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 89,5% нь хөдөлмөр эрхлэх насны хүмүүс байгаагаас 44,8% нь хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс 74 нь буюу 3% нь төсөвт байгууллагуудад, 1244 нь буюу 50,7% нь хувийн секторт, 1131 буюу 46,1% нь хөдөө орон нутагт мал маллан амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийн түвшин доогуур байгаа нь нэг талаас тэд халамжийн үйлчилгээнд хамрагдах сонирхол их, бэлэнчлэх сэтгэлгээтэй, өөрсдийн нөөц бололцоогоо дайчлан хөгжүүлж амьдрах идэвх, чармайлтгүй байгаа, нөгөө талаас тэднийг бие махбодын болон гадаад байдлаас хамааран аж ахуйн нэгж байгууллагууд ажилд авдаггүй нь тэдний амьдралд ихээхэн нөлөөлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 1796 хүүхэд байгаагийн 142 нь буюу 8% нь л боловсролын үйлчилгээнд хамрагдаж, бусад нь сургуулиас гадна байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хязгаарлагдмал чадавхи боломжийг ойлгож хүндэтгэх, онцлог хэрэгцээнд нь тулгуурласан үйлчилгээг сайжруулах замаар тэднийг дэмжин хөгжүүлэх, үүнд нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх шаардлагатай.

Энэхүү хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх замаар нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог нь нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшинг бууруулахад чиглэгдэж, нийгмийн хамгаалал, аж байдалд нь түлхүү анхаарснаараа онцлог юм.

### **Хоёр. Зорилго:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлж амьдралын чанарыг сайжруулахад оршино.

### **Гурав. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим:**

#### **Тэгш байдлын зарчим**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг жирийн иргэдийн нэгэн адилаар нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах боломжийг тусгасан байна.

#### **Боломж олгох зарчим**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг олгосон байна.

#### **Дэмжлэг үзүүлэх зарчим**

Нийгмийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

#### **Бодлогыг уялдуулах зарчим**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төрийн бодлогыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулсан байна.

#### **Хүртээмжтэй байх зарчим**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хөгжлийн аливаа үйл явцад бүрэн хамруулж, түүний үр шимийг хүртэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### **Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Нийгмийн хамгааллыг сайжруулах” хөтөлбөрийг 2015-2017 онд хэрэгжүүлнэ.

#### **Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилт

Нийгмийн халамжийн сан

Олон нийтийн оролцоо түшиглэсэн халамжийн үйлчилгээний санхүүжилт

Олон улсын төсөл хөтөлбөрүүд

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын жилийн үйл ажиллагааны төсөв

**Тав. Зорилт:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог чадавхид нийцсэн ажлын байр бий болгох замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг хөгжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх

3. Хөгжлийн бэрхшээлтэй болхоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлж, эрүүл мэндийн сэргээн засалтын үйлчилгээг сайжруулах

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол мэргэжил олгох, тэднийг чадваржуулах, тэдгээртэй ажиллах боловсон хүчнийг бэлтгэх

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёл урлаг, спорт нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлэх замаар эрхийг бодитой болгох

6. Салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж статистик тоо мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэх

7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг сайжруулах.

**Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**Зорилт -1**

**6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог чадавхид нийцсэн ажлын байр бий болгох замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих**

6.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад үндэслэн тэднийг мэргэжлийн сургалт болон аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах

6.1.2. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хуульд заасан хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд нөхөн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуримтлуулах асуудлыг эрчимтэй зохион байгуулах

6.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувиараа хөдөлмөр эрхлэх, сайн дураараа нэгдэн орлогоо нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас буцалтгүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Тэгш дүүрэн хөтөлбөрийн зээлийн эргэлтийн сангаас барьцаа хөрөнгөгүй зээл олгох

6.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтанд дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн, яармаг худалдааг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах;

6.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангасан ажил олгогчыг урамшуулах, дэмжих

### **Зорилт – 2**

**6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадамжийг илрүүлж олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг хөгжүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэх**

6.2.1. Өрхийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор жижиг төсөл хөтөлбөрүүдэд хамруулах

6.2.2. Олон нийтийн оролцоо түшиглэсэн халамжийн үйлчилгээнд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах, үүсгэл санаачллын бүлэг болон өөрөө өөртөө туслах бүлгийн орлогыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийгмийн ажлын арга зүйн дэмжлэг үзүүлэх, санхүүжилт олгох

6.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд сэргээн засах, зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах талаар боломж нөөцийг судалж, хэрэгжүүлэх

6.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сувиллыг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан нээн ажиллуулах

6.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг тогтвортой ажиллуулах

6.2.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг нийгмийн ажилтны чадавхийг сайжруулах;

6.2.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх хандлагын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, телевизийн мэдээлэл бэлдэх

6.2.8 Тэгш дүүрэн хөтөлбөрийн санхүүжилтээр бий болсон малын эргэлтийн санг үр дүнтэй хэрэгжүүлэх

### **Зорилт – 3**

**6.3. Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлж, эрүүл мэндийн сэргээн засалтын үйлчилгээг сайжруулах**

6.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний алдагдсан чадварыг нөхөн сэргээх, орлуулах протез, ортопедийн мужааны цехийн үйл ажиллагааг тогтмолжуулж, протез, ортопедийг шаардлагатай иргэдэд олгох үйл ажиллагааг зохион байгуулах

6.3.2. Эрүүл аж төрөх ёсонд сургах, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг зохион байгуулах;

6.3.3. Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах

6.3.4. Удамшлын өвчний шалтгааныг тогтоон дараагийн үе удамд дамжихаас хамгаалах арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;

6.3.5. Эрүүл мэндийн талаархи эцэг, эхийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж эмгэг согогтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх

6.3.6. Сэргээн засалч бэлтгэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд сэргээн засах чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах

6.3.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зориудын болон урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж зохих арга хэмжээ авах

#### **Зорилт – 4**

**6.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол мэргэжил олгох, тэднийг чадваржуулах, тэдгээртэй ажиллах боловсон хүчнийг бэлтгэх**

6.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, орон нутгийн телевизүүдийг хэлмэрчтэй болгох зорилгоор нэвтрүүлэгчдийг дохионы хэлний сургалтанд хамруулах

6.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах үйл явцад үнэлгээ өгч, нэмэгдүүлэх арга хэмжээ авах

6.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол нөхөн олгох сургалтыг зайны болон танхимын хэлбэрээр тогтмол хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулах

6.4.4. Эсгий урлал, талх нарийн боов, оёдол, мужаан зэрэг мэргэжлээр амьдрах ухааны сургалт зохион байгуулах

6.4.5. “Ирээдүй XXI зуун” сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжигч түшиц сургууль болгох

6.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтийг үндэслэн хувьсах зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах

#### **Зорилт - 5.**

**6.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёл, спорт нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлэх замаар эрхийг бодитой болгох**

6.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлаг, спортын наадмыг жилд нэг удаа зохион байгуулж хэвших

6.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг пара олимп болон улсын чанартай уралдан тэмцээнд оролцож амжилт гаргахад нь дэмжлэг үзүүлж урамшуулдаг механизм бий болгох

### **Зорилт – 6**

**Салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж статистик тоо мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэх**

6.6.1. Нас, хүйс, амьжиргааны түвшин болон хөдөлмөрийн чадвар алдалтын төрөл, хэлбэр зэргээр ангилсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи мэдээллийг цуглуулж нэгдсэн сантай болох

6.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх

### **Зорилт-7**

**6.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох боломжийг бүрдүүлж, ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг сайжруулах**

6.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулагдсан тусгай тоног төхөөрөмж бүхий тээврийн хэрэгсэлтэй болгох асуудлыг шийдвэрлэх;

6.7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олноор үйлчлүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг стандартын налуу замтай болгох асуудлыг эрчимжүүлэх

6.7.3. Хүн ихээр үйлчлүүлдэг ААН, байгууллагууд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арижн цэврийн өрөөг бий болгох, халуун усанд орох нөхцөл бололцоог хангах

6.7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн зураг төсөв хийж улсын төсөвт тусгуулах арга хэмжээг авах

### **Долоо. Хөтөлбөрийн хяналт, удирдлага, зохион байгуулалт, үр дүн:**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг салбарын агентлагууд хагас жил тутамд сумдаас авч нэгтгэн аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэст ирүүлэх бөгөөд тус хэлтэс болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг хамтран хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана.

Сум орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан тушаалтнуудыг хариуцсан агентлагууд болон ажлын хэсэг байнгын удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж хэрэгжилтэнд тогтмол хяналт тавина.

### **Найм. Хөтөлбөрийн үр дүн, хүрэх түвшин**

Чөлөөтэй саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн барилга байгууламж, зам талбайн тоог 2 дахин нэмэгдүүлсэн байна.

Мэдээлэл хүртэх боломж сайжирч, нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдсэн байна.

Хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй мэргэжил эзэмших, ур чадвараа дээшлүүлэхэд чиглэсэн мэргэжлийн сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, хувиараа хөдөлмөр эрхэлж орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн тэдний хөдөлмөр эрхлэх таатай нөхцөлийг бий болгож 2015-2017 онд 810 байнгын, шинэ ажлын байрыг бий болгосон байна.

Хэрэгцээ, онцлогт нь тулгуурласан боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулж 2015-2017 онд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 20%-ийг боловсролын үйлчилгээнд хамруулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи статистик мэдээ, мэдээлэл, судалгаа сайжирч, тэдний мэдээлэл авах боломж нэмэгдэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн иж бүрэн мэдээллийн сантай болсон байна.

Урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл буурч, эрүүл мэндийн байдал сайжирсан байна.

Чадварыг нөхөн сэргээх, хэвийн түвшинд хүрэхэд нь туслах, амьдралаа өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.



**ЕС. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилт	Хугацаа
1	<b>9.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог чадавхид нийцсэн ажлын байр бий болгох замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:</b>				
2	9.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад үндэслэн тэднийг мэргэжлийн сургалт болон аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах	Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗД	ХЭДС-24 сая Аж ахуй эрхлэлтийн сургалтанд-150, мэргэжлийн сургалтанд-75 хүн хамруулна.	2015-2017 онд
3	9.1.2. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хуульд заасан хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд нөхөн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуримтлуулах асуудлыг эрчимтэй зохион байгуулах	Хөдөлмөрийн хэлтэс	ААНБ-ууд	Аж ахуйн нэгж байгууллагаас 3 жилийн хугацаанд нийт 24 сая төгрөгийг ХЭДС-нд төвлөрүүлнэ. 393 хүнийг ажлын байраар хангана.	2015-2017 онд
4	9.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувиараа хөдөлмөр эрхлэх, сайн дураараа нэгдэн орлогоо нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас буцалтгүй зээл тусламж, Тэгш дүүрэн хөтөлбөрийн зээлийн эргэлтийн сангаас барьцаа хөрөнгөгүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Хөдөлмөрийн хэлтэс	Тэгш дүүрэн хороо	170 иргэнд 255 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг ХЭДС-аас, 36 иргэнд 25 сая төгрөгийг Тэгш дүүрэн хорооны зээлийн эргэлтийн сангаас олгох	2015-2017 онд
5	9.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтанд дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн, яармаг худалдааг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах;	Хөдөлмөрийн хэлтэс	НХХ		2015-2017 онд
6	9.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг урамшуулах, дэмжих	Хөдөлмөрийн хэлтэс	Сумдын ЗД нар	22 ААНБ-д ХЭДС-аас 26,4 сая төгрөгийн урамшуулал олгох	2015-2017 онд

<b>9.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй иргэдтийн чадамжийг илрүүлж олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг хөгжүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэх</b>					
7	9.2.1. Өрхийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор жижиг төсөл хөтөлбөрүүдэд хамруулах	НХҮХ,	ЭМГ, ХХ, Тэгш дүүрэн хороо	ХЭДС, Тэгш хөтөлбөрийн санхүүжилт	2015-2017 онд
8	9.2.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зорилтот бүлгийн иргэдийг хамруулах, үүсгэл санаачлагын бүлэг болон өөрөө өөртөө туслах бүлгийн орлогыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийгмийн ажлын арга зүйн дэмжлэг үзүүлэх, санхүүжилт олгох	НХҮХ	Сумдын ЗД нар	ОНОТХҮ-ний санхүүжилт	2016-2017 онд
9	9.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сэргээн засах , зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах	НХҮХ,	Чийрэгжүүлэлтийн төвүүд	ОНОТХҮ-ний санхүүжилт	2015-2017 онд
10	9.2.4. Ахмад настны "Эрчим" амралтын газрыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сувилал болгон ажиллуулах	НХҮХ		Халамжийн сан	2015-2017 онд
11	9.2.5. ХБХүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг тогтвортой ажиллуулах	НХҮХ	Салбар хороо	Салбар хорооны төсөв - 115 сая	2015-2017 онд
12	9.2.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг нийгмийн ажилтны чадавхийг сайжруулах;	НХҮХ,			2015-2017 онд
13	9.2.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх хандлагын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, телевизийн мэдээлэл бэлдэх	НХҮХ,	Тэгш дүүрэн хороо	Тэгш дүүрэн хөтөлбөрийн төсөв	2015-2017 онд
14	9.2.8. Тэгш дүүрэн хөтөлбөрийн санхүүжилтээр бий болсон малын эргэлтийн санг үр дүнтэй хэрэгжүүлэх	Тэгш хороо	Тэгш дүүрэн	Тэгш дүүрэн хөтөлбөрийн төсөв	2015-2017 онд
<b>9.3. Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлж, тэдний бие бялдар, мэдрэхүй, сэтгэц, оюун санаа, эрүүл мэндийн сэргээн засалтын үйлчилгээг сайжруулах</b>					
15	9.3.1. хөгжлийн бэрхшээлтэй иргэний алдагдсан чадварыг нөхөн сэргээх, орлуулах	Тэгш хороо	Тэгш дүүрэн НХҮХ, ХГБХХ	Нийгмийн халамжийн сан	2015-2017 онд

	протез, ортопедийн мужааны цехийн үйл ажиллагааг тогтмолжуулж, протез, ортопедийг шаардлагатай иргэдэд олгох үйл ажиллагааг зохион байгуулах	ЭМГ			Сумдын ЭМТ-үүд	Байгууллагын жилийн төсвөөс	2015-2017 онд
16	9.3.2. Эрүүл аж төрөх ёсонд сургах, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг зохион байгуулах;	ЭМГ			Тэгш дүүрэн хороо	Байгууллагын жилийн төсвөөс, Тэгш дүүрэн хорооны ажиллагааны зардлаас	2015-2017 онд
17	9.3.3. Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, ХБИ-д нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах	ЭМГ			Сумдын ЭМТ-үүд		2015-2017 онд
18	9.3.4. Удамшлын өвчний шалтгааныг тогтоон дараагийн үе удамд дамжихаас хамгаалах арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;	ЭМГ			ХГБХХ		2015-2017 онд
19	9.3.5. Эрүүл мэндийн талаархи эцэг, эхийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж эмгэг согогтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх	ЭМГ			Тэгш дүүрэн хороо		2015-2017 онд
20	9.3.6. Сэргээн засалч бэлтгэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд сэргээн засах чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах	ЭМГ			Сумдын ЭМТ-үүд		2015-2017 онд
21	9.3.7. ХБИ-ийг зориудын болон урдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж зохих арга хэмжээ авах	ЭМГ					
<b>9.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол мэргэжил олгох, тэднийг чадваржуулах, тэдгээртэй ажиллах боловсон хүчнийг бэлтгэх зорилтыг хангахын тулд</b>							
22	9.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, орон нутгийн телевизүүдийг хэлмэрчтэй болгох зорилгоор нэвтрүүлэгчдийг дохионы хэлний сургалтанд хамруулах	БСГ, ХГБХХ		Орон нутгийн телевизүүд	Байгууллагын төсөв		2015-2017 онд
23	9.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг өргөжүүлэх, боловсрол олгох төвийн тоог нэмэгдүүлэх	БСГ, ХГБХХ		Өвгөд төв	сургалтын		2015-2017 онд
24	9.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол нөхөн олгох сургалтыг зайны	БСГ		Албан боловсролын	бус боловсролын	Боловсролын жилийн төсөв	2015-2017 онд

	болон танхимын хэлбэрээр тогтмол хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулах			сургалтын төвүүд		
25	9.4.4. Эсгий урлал, талх нарийн боов, оёдол, мужаан зэрэг мэргэжлээр амьдрах ухааны сургалт зохион байгуулах	БСГ	Албан боловсролын сургалтын төвүүд	бус боловсролын төсөв	жилийн	2015-2017 онд
26	9.4.5. Ирээдүй сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжигч түшиц сургууль болгох	БСГ	Ирэдүй 21-р зуун ЕБС	ОУ-ын хөтөлбөрөөр	төсөл,	2015-2017 онд
27	9.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтийг үндэслэн хувьсах зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах	БСГ	Салбар комисс	Боловсролын төсөв		2015-2017 онд
	<b>9.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёл, спорт нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлэх замаар эрхийг бодитой болгох</b>					
28	9.5.1. ХБИ-ийн урлаг, спортын наадмыг жилд нэг удаа зохион байгуулж хэвших	ХБИ-ийн холбоодууд	БТСГ, ХДТ	Нийгмийн сан	халамжийн	2015-2017 онд
29	9.5.2. ХБИ-ийг паралимп болон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож амжилт гаргахад нь дэмжлэг үзүүлж урамшуулдаг механизм бий болгох	НХҮХ, НХХ	БТСГ	Сумдын шийдвэрийг Нийгмийн сан	АДЗ-ийн үндэслэн халамжийн	2015-2017 онд
	<b>9.6. Салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж статистик тоо мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэх</b>					
30	9.6.1. Нас, хүйс, амьжиргааны түвшин болон хөдөлмөрийн чадвар алдалтын төрөл, хэлбэр зэргээр ангилсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи мэдээллийг цуглуулж нэгдсэн сантай болох	НХҮХ	БСГ, ХГБХХ, НХҮХ, ЭМГ, Тэлш дүүрэн хороо	Жил бүрийн 6, 12 дугаар саруудад удирдлагаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч нэгдсэн санг үүсгэх		2015-2017 онд
31	9.6.2. ХБИ-дэд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх	НХҮХ	ЭМГ, НДХ, БСГ, ХХ			2015-2017

9.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг сайжруулах						
32	9.7.1. Хөгжлийн иргэдэд зориулагдсан тусгай тоног төхөөрөмж бүхий тээврийн хэрэгсэлтэй болгох асуудлыг шийдвэрлэх;	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулагдсан тусгай тоног төхөөрөмж бүхий тээврийн хэрэгсэлтэй болгох асуудлыг шийдвэрлэх;	Аймгийн ЗДТГ-ын ХБХ, НХХ	Аймгийн ХАА-ны алба	ОНХС-ийн 2015 оны санхүүжилт- 60 сая	2015-2017 онд
33	9.7.2. ХБИ олноор үйлчлүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг стандартын налуу замтай болгох асуудлыг эрчимжүүлэх	9.7.2. ХБИ олноор үйлчлүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг стандартын налуу замтай болгох асуудлыг эрчимжүүлэх	НХҮХ	ААНБ-ууд	ААН, Байгууллагуудын төсөв	2015-2017 онд
34	9.7.3. Хүн ихээр үйлчлүүлдэг ААН, байгууллагууд ХБИ-дэд зориулсан ОО-ийг бий болгох, халуун усанд орох нөхцөл бололцоог хангах	9.7.3. Хүн ихээр үйлчлүүлдэг ААН, байгууллагууд ХБИ-дэд зориулсан ОО-ийг бий болгох, халуун усанд орох нөхцөл бололцоог хангах	НХҮХ, ТББ-ууд	ААНБ-ууд	ААНБ-уудын төсөв	2015-2017
35	9.7.4. ХБИ-ийн хөгжлийн төвийн зураг төсөв хийж улсын төсөвт тусгуулах арга хэмжээг авах	9.7.4. ХБИ-ийн хөгжлийн төвийн зураг төсөв хийж улсын төсөвт тусгуулах арга хэмжээг авах	НХХ, ТББ-ууд	НХҮХ	Улсын төсөв	2015-2017

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2015 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн  
59... дүгээр тогтоолын 02 дугаар хавсралт

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах  
аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Ганболд /Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга/

Нарийн бичгийн дарга: Д.Дуламжав /Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний  
хэлтсийн дарга/

Гишүүд:

Д.Цэцэгмаа /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн  
мэргэжилтэн

Н.Цэндмаа /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн  
мэргэжилтэн, Тэгш дүүрэн хорооны нарийн бичгийн дарга/

Б.Мөнгөн-Эрдэнэ /Хөдөлмөрийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/

Э.Дагиймаа /Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн/

Д.Баасансүрэн /Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн/

н.Галбадрах /тохиролцсоноор/ Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн  
холбооны тэргүүн